

“ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ТӨВТЭЙ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА, ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ



Монгол улс нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэх, бэлгийн мөлжлөгт ашиглах зорилгоор худалдаалах гэмт хэргийн илгээгч, хүлээн авагч, дамжин өнгөрөгч улсуудын нэгт тооцогдож байна. Монгол Улсын Засгийн газар сүүлийн жилүүдэд хүн худалдаалах гэмт хэрэгтэй (ХХГХ) тэмцэх чиглэлээр хууль эрх зүйн орчинд тодорхой ахиц дэвшил гаргасан ч хохирогчийг илрүүлэх, хамгаалах, нөхөн төлбөр олгох зэрэг асуудлууд дутагдалтай хэвээр байна. Азийн сан Монгол улсад хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын шатны хяналт шалгалтыг сайжруулан бэхжүүлэх үүднээс ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр ажилладаг байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Азийн сан Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ), Хууль сахиулахын их сургуультай (ХСИС) хамтран Монгол улсын хууль эрх зүйн болон бүтцийн шинэчлэлийг дэмжих, бэхжүүлэхэд чиглэсэн энэхүү төслийг санаачлан хэрэгжүүлж байна. Энэ төсөл нь хууль сахиулах байгууллагуудын ажилтнууд, прокурор, шүүгч, хил хамгаалах байгууллага, Гадаадын иргэн, харьяатын газрын (ГИХГ) алба хаагчдад зориулсан хохирогчид төвлөрсөн мөрдөн шалгалт, хяналтыг сайжруулах, хохирогчийг илрүүлэх, хамгаалах шилдэг туршлагыг нэвтрүүлэхэд чиглэсэн цогц сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтуудыг зохион байгуулах юм. Төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах үүднээс хамтрагч байгууллагууд шинэ сургалтын хөтөлбөр ашиглан орон даяар ХХГХ-тэй тэмцэх сургалтуудыг зохион байгуулна.

Монгол улсын Засгийн газар ХХГХ-тэй тэмцэх үүргээ биелүүлэх, хохирогч хамгааллыг сайжруулах чиглэлээр гаргаж буй хүчин чармайлтыг уялдуулах хүрээнд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012), Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль (2014)-ийг шинээр баталж, Эрүүгийн хуулийг шинэчлэн батлаад байна. Эдгээр эрхзүйн болон бүтцийн шинэчлэлүүд нь Монгол улсад ХХГХ-тэй тэмцэх нэгдмэл, цогц аргачлалыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байгаа ч тэдгээрийг хэрэгжүүлэхэд ХЗДХЯ болон түүний

харьяа агентлагуудад хүндрэл бэрхшээл тулгарсаар байна. Хууль сахиулах, шүүгч, прокурор, хил хамгаалах байгууллага болон ГИХГ-ын алба хаагчид ХХГХ-ийн талаар болон ХХГХ-тэй холбоотой сүүлийн үеийн хууль тогтоомжийн талаар жигд бус ойлголттой байна. Эдгээр байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо дутмаг байгаа бөгөөд хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэх тал дээр хамтран ажиллах туршлага бага байна. Заримдаа хууль сахиулах байгууллагын алба хаагчдад ХХГХ-ийн гэрч хохирогчтой мэдрэмжтэйгээр ойлгон харьцах, хамтран ажиллах шаардлага бүхий ур чадвар үгүйлэгддэг. Прокурорууд ХХГХ дээр ажиллахдаа нотлох баримт цуглуулах, хэргийг шүүх хурал дээр нотлох зэрэгт мэргэжлийн мэдлэг чадвараа сайжруулах хэрэгцээ байсаар байна. Мөн хил хамгаалах байгууллагын алба хаагчид болзошгүй хохирогчийг илрүүлэх, хохирогчид туслалцаа үзүүлэхдээ хаана хэрхэн хандах талаар практик сургалт явуулах шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Хоёр жилийн хугацаанд хэрэгжих энэхүү төслийн зорилго нь Монгол улсад ХХГХ-ийн хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын шатны хяналт шалгалтыг сайжруулахад оршино.



6 Семинар

Хууль сахиулахын их сургуулийн сонсогчид



7 Сургалт

Хил хамгаалах болон гадаадын иргэн, харьяатын газрын алба хаагчид



5 Сургалт

Хууль сахиулах байгууллагын алба хаагчид, прокурор, шүүгч



Зорилт 1: Хохирогч төвтэй стратеги хэрэгжүүлэх, хууль сахиулах байгууллагуудын алба хаагчид, прокурор, шүүгчдийн хамтын ажиллагааг сайжруулах

Азийн сан Монгол улсад ХХГХ-ийг мөрдөн байцаах хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэх асуудлаар үйл ажиллагааны судалгаа хийж, тус судалгаанаас гарсан үр дүнд тулгуурлан ХЗДХЯ, ХСИС-тай хамтран хохирогч төвтэй сургалтын хөтөлбөр боловсруулж, хууль сахиулах байгууллагын алба хаагчид, прокурор, шүүгч нарт зориулан тэдний ур чадварыг сайжруулах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх сургалтууд зохион байгуулна.

Зорилт 2: Хил хамгаалах байгууллага болон ГИХГ-ын алба хаагчдын ХХГХ-ийн хохирогчийг илрүүлэх, хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулах

Үйл ажиллагааны судалгаа, шинэчлэн боловсруулсан сургалтын хөтөлбөрт суурилан Азийн сан хил хамгаалах байгууллага болон ГИХГ-ын алба хаагчдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, ХХГХ-ийн болзошгүй хохирогчийг илрүүлэх, хохирогчийг хамгаалах, хохирогчид дэмжлэг үзүүлэхээр туслалцаа хүсэх асуудлаар хэрхэн бусад байгууллагуудтай хамтран ажиллах асуудлаар цогц сургалтуудыг зохион байгуулна.

ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР АЗИЙН САНГААС ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД:

Азийн сан 2002 оноос хойш Монгол улс дахь ХХГХ-ийн асуудалд анхаарлаа хандуулж, тус асуудлын эсрэг нэн тэргүүнд тэмцээр ирсэн. Энэ гэмт хэрэгтэй тэмцэхдээ төрийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь манай байгууллагын хувьд

хамгийн чухал арга зам байсаар ирсэн. Азийн сан Монгол улсад гарч буй ХХГХ-ийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх ажлууд зохион байгуулж, ХХГХ-тэй тэмцэх төрийн хүчин чармайлтыг дэмжиж, хууль сахиулах байгууллагын алба хаагч, прокурор, шүүгч нарт тус гэмт хэргийг мөрдөн байцаах, хянан шалгах, гэмт хэрэгтнийг шүүх, хохирогчийг хамгаалах чиглэлээр цуврал сургалтуудыг зохион байгуулах замаар ХХГХ-тэй тэмцэх олон төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсээр ирсэн туршлагатай. Түүнчлэн Азийн сангаас ХЗДХЯ дээр ХХГХ-тэй тэмцэх Дэд Зөвлөл байгуулах ажилд дэмжлэг үзүүлж, 2017 оны 5 дугаар сард батлагдсан ХХГХ-тэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулахад үүрэг гүйцэтгэсэн.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:

2017 оны 4-р сараас 2019 оны 3-р сар хүртэл

ТӨСЛИЙН САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

АНУ-ын Төрийн департаментын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх алба

ТӨСЛИЙГ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД:

Хууль зүй, дотоод хэргийн яам болон Хууль сахиулахын их сургууль



Санхүүжилтийг АНУ-ын Засгийн газраас олгов.

Азийн сан нь ашгийн бус, төрийн бус, олон улсын хөгжлийн байгууллага бөгөөд АНУ-ын Сан Франциско хотод төвтэй, Азийн 18 орон болон АНУ-ын Вашингтон Ди Си хотод салбаруудтай. Төр, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагуудтай хамтран засаглал, эдийн засгийн хөгжил, эмэгтэйчүүдийг чадавхжуулах, байгаль орчныг хамгаалах, бүс нутгийн хамтын ажиллагааг дэмжих зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.



Төв байр
465 Калифорни гудамж, 9-р давхар, Сан Франциско хот, СА
94104 АНУ
Утас (415) 982-4640
Факс: (415) 392-8863

Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
Ориент Плаза, 3-р давхар
Г.Чагдаржавын гудамж
Төв шуудан, ш/х 1003
Улаанбаатар хот, 14210
Монгол улс
Утас: 976-11-330524
www.asiafoundation.org